



2026 он 05 сар 20 өдөр


Дугаар 18

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Алтангэрэл овогтой Жаргалмаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг үндэслэн түүнийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөр ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д даалгасугай.

ТУЗ-ийн дарга   У.БААТАРСАЙХАН



2026 он 05 сар 20 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, 77.6, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.8, 6.2.14 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Равжин овогтой Саранцэцэгийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2027 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэлх хугацаагаар түр томилсугай.
2. Шинээр томилогдсон ТУЗ-ийн хараат бус гишүүн Р.Саранцэцэгт Компанийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм журмын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх бүхий байгууллага болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (М.Сэлэнгэ)-д даалгасугай.





2026 он 05 сар 20 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81-р зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.8, 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбогдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Хавсралт 1-ээр шинэчлэн томилсугай.
2. Шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.



Ц.БААТАРСАЙХАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 05-р сарын 20-ны өдрийн хурлын
20-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод		Бүрэлдэхүүн	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	хараат бус гишүүн	Д. Гэрэлмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д. Хүрэлбаатар
	гишүүн	ердийн гишүүн	Д. Хулан
Цалин урамшууллын хороо	дарга	хараат бус гишүүн	Д. Хүрэлбаатар
	гишүүн	хараат бус гишүүн	Р. Саранцэцэг
	гишүүн	ердийн гишүүн	Б. Оргил
Эрсдэл, аудитын хороо	дарга	хараат бус гишүүн	Р. Саранцэцэг
	гишүүн	хараат бус гишүүн	Д. Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Б. Цээням